



I/2022


Тархаасан: 2022 оны 2 дугаар сарын 16



Нас гүйцсэн эр хонины үнэ Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 300.0 мянган төгрөг байна


Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2022 оны 1 дүгээр сард атны үнэ 1.4 сая төгрөг болж, өмнөх сараас 18.0 мянган төгрөг, соёолон үрээнийх 1.1 сая төгрөг болж, өмнөх сараас 15.4 мянган төгрөгөөр тус тус өсөж, хязаалан гуных 1.3 сая төгрөг болж, өмнөх сараас 8.7 мянган төгрөгөөр буурсан байна. Эр хонины үнэ 211.2 мянган төгрөг болж, өмнөх сараас 3.3 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 159.7 мянган төгрөг болж, өмнөх сараас 9.1 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 1. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ (сум), 2022 оны 1 дүгээр сард, мянган төгрөгөөр




Эр хонины 2022 оны 1 дүгээр сард Улаанбаатар хотод хамгийн их буюу 300.0 мянган төгрөг болж, өмнөх сараас өөрчлөлтгүй, Хөвсгөл аймагт хамгийн бага буюу 174.4 мянган төгрөг болж, өмнөх сараас 3.6 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 2. НАС ГҮЙЦСЭН ЭР ХОНИНЫ ДУНДАЖ ҮНЭ, 2022 оны 1 дүгээр сард




Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2022 оны 1 дүгээр сард боодолтой өвсний (20кг) үнэ Өмнөговь аймагт хамгийн их буюу 12.2 мянган төгрөг, Сэлэнгэ аймагт хамгийн бага буюу 2.9 мянган төгрөг байна.

ЗУРАГ 3. БООДОЛТОЙ ӨВСНИЙ ДУНДАЖ ҮНЭ, 2022 оны 1 дүгээр сард



Үхрийн 2 метрээс дээш урттай шир 2022 оны 1 дүгээр сард 8.3 мянган төгрөг болж, өмнөх сараас өөрчлөлтгүй, харин ямааны цагаан ноолуур 1 кг-ын үнэ 102.1 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.9 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 4. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 1 дүгээр сард, төгрөг



Хивэгний (25 кг) үнэ 2022 оны 1 дүгээр сард Орхон аймагт хамгийн их буюу 25.0 мянган төгрөг, Төв аймагт хамгийн бага буюу 17.7 мянган төгрөг байна.

Тооцох аргачлал:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.



Эх үүсвэр:

ҮСХ, ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ

Мэдээлэл авах холбоос

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 3 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын дарга

А.Дэмбэрэл

Утас : (976-51)-329272

Эдийн засгийн статистикийн газрын

Үнийн статистикийн хэлтсийн гэрээт

ажилтан Б. Оргил

Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212